



**МОНГОЛ УЛСЫН
ЭРЧИМ ХҮЧНИЙ ЯАМ**

Засгийн газрын XIV байр, Чингисийн өргөн чөлөө,
Хан-Уул дүүрэг, Улаанбаатар хот, 17060
Утас: 26 30 51, Факс: (976) 7004 3479,
Цахим шуудан: info@energy.gov.mn

2025.03.10 № 8/781
танай _____-ны № _____-Т

Чиглэл хүргүүлэх тухай


Төсвийн ерөнхийлөн захирагчийн дэргэдэх Дотоод аудитын хорооны 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу эрчим хүчний салбарт 2024 оны жилийн эцсийн байдлаарх Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн байдалд дотоод аудитыг гүйцэтгэж, 48 байгууллагын шилэн дансны цахим хуудас хөтлөлтийг хамруулав. Дотоод аудитаар нийт 40 байгууллага цахим хуудсанд хугацаа хоцроож мэдээлэл байршуулсан, 33 байгууллага мэдээллийн агуулга, стандартыг баримтлаагүй, 9 байгууллага тайланг хугацаанд нь илгээгээгүй алдаа илэрсэн байна.

2024 оны жилийн эцсийн Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг 95.8 хувь гэж үнэлсэн ба өмнөх оны мөн үетэй харьцуулахад 3.5 хувиар өссөн эерэг үзүүлэлт гарсан байна.

Цаашид хууль тогтоомжийн биелэлтийг ханган, дотоод аудитын зөвлөмжийг хэрэгжүүлж, алдаа зөрчлийг давтан гаргахгүй байхад анхаарч ажиллана уу.

Хавсралт № хуудастай.

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ,
ДОТООД АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА



Х.БЕКБОЛАТ

170600000906



ЭРЧИМ ХҮЧНИЙ ЯАМНЫ
ДОТООД АУДИТЫН ХОРООНЫ
ТОГТООЛ

2025 оны 04 сарын 16 өдөр

№ 2572.

Улаанбаатар хот

Дотоод аудитын дүн батлах,
зөвлөмж хэрэгжүүлэх тухай

Төсвийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 3, Шилэн дансны тухай хуулийн 8.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд 2024 оны жилийн эцсийн байдлаар хийсэн дотоод аудитын дүн, зөвлөмжийг баталсугай.

2. Дотоод аудитын зөвлөмжийн биелэлтийг хангаж, Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж ажиллахыг эрчим хүчний салбарын байгууллагын удирдлагуудад үүрэг болгосугай.

3. Дотоод аудитын зөвлөмжийн биелэлт, түүний мөрөөр авч хэрэгжүүлж буй арга хэмжээний хэрэгжилтэд хяналт тавьж, Дотоод аудитын хороонд танилцуулж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар /Х.Бекболат/-т даалгасугай.

САЙД, ДОТООД АУДИТЫН
ХОРООНЫ ДАРГА



Б.ЧОЙЖИЛСҮРЭН

ДОТООД АУДИТЫН НЭГЖ: ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД
АУДИТЫН ГАЗАР

ДОТООД АУДИТЫН АЖЛЫН ТАЙЛАН

Аудитын нэр: Шилэн дансны тухай хуулийн 2024 оны
жилийн эцсийн байдлаарх хэрэгжилтэд
хийсэн дотоод аудит

2025 он

Аудитын талаарх товч мэдээлэл

Аудит хийгдсэн объект: ШИЛЭН ДАНСНЫ АУДИТ

Аудитын төрөл: Дотоод аудит

Аудитын хугацаа: 2025.01.27 - 2025.02.21

**Дотоод аудитын
нэгжийн дарга:**

Эрчим хүчний яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ,
дотоод аудитын газрын дарга Х.БЕКБОЛАТ

Аудит хийсэн:

Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод
аудитын газрын Шинжээч Н.АМАРТӨВШИН

Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод
аудитын газрын ахлах мэргэжилтэн Т.МӨНХЗУЛ

АГУУЛГА

1. ТАНИЛЦУУЛГА

2. АУДИТЫН ЗОРИЛГО, ЦАР ХҮРЭЭ

2.1 Аудитын зорилго

2.2 Аудитын цар хүрээ

3. АУДИТЫН ҮР ДҮН

Илэрсэн асуудлууд

4. НЭГДСЭН ДҮГНЭЛТ

НЭГ. ТАНИЛЦУУЛГА

Эрчим хүчний сайдын 2025 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн А/40 дүгээр тушаалаар баталсан удирдамжийн дагуу 2024 оны жилийн эцсийн байдлаар Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд дотоод аудитыг хийж гүйцэтгэв.

Дотоод аудитыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга Х.Бекболат хянан удирдаж, дотоод аудит хариуцсан шинжээч Н.Амартөвшин, ахлах мэргэжилтэн Т.Мөнхзул нар 2025 оны 01 дүгээр сарын 24-ний өдрөөс 2024 оны 02 дугаар сарын 21-ний өдрийг дуустал хугацаанд хийж гүйцэтгэв.

Дотоод аудитаар:

Эрчим хүчний сайдын эрхлэх асуудлын хүрээнд багтах Төрийн өмчит компани 34, төрийн өмчит үйлдвэрийн газар 2, төсөл хөтөлбөр 10, төсвийн ерөнхийлөн захирагч, эрчим хүчний яам зэрэг нийт 48 байгууллагыг шилэн дансны аудитад хамруулав.

ХОЁР. АУДИТЫН ЗОРИЛГО, ЦАР ХҮРЭЭ

2.1. Аудитын зорилго:

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд дотоод аудит хийж, дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж, зөвлөмж өгөхөд оршино.

2.2. Аудитын хамрах хүрээ:

Аудитыг Эрчим хүчний сайдын эрхлэх асуудлын хүрээнд багтах Шилэн дансны хуулийн 3.1.1, 3.1.2, 3.1.3, 3.1.4, 3.2.6-д заасан хуулийн этгээд, байгууллага, албан тушаалтнууд **2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар** хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээлэл болон "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын дагуу байршуулсан эсэхийг дотоод аудитад хамруулсан.

Аудитын дүн, дүгнэлтэд дэмжлэг болох нотлох зүйлс, холбогдох мэдээ судалгааг ажлын баримт материалд хавсаргав.

2.3 Аудитын арга, аргачлал:

Дотоод аудитыг Сангийн сайдын 2019 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн 268 дугаар тушаалаар баталсан "Улсын салбарын дотоод аудитын аргачлал"-ын хүрээнд доорх хууль тогтоомж, эрх зүйн баримт бичгийн хүрээнд хийв. Үүнд:

- Шилэн дансны тухай хууль;
- Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам";
- Дотоод аудитын мэргэжлийн практикийн олон улсын стандарт

Аудитын арга зүй, горимын дагуу шилэн дансны цахим хуудсанд байршуулсан мэдээлэл нь хууль болон журамд нийцэж, мэдээллийн талбар хоорондын уялдаа хангасан, тайлагнал үнэн, зөв, иж бүрэн, нийтэд ойлгомжтой байгаа эсэхийг цахим хуудаснаас татаж авч түүвэрчлэн шалгах, тулган баталгаажуулах, холбогдох албан тушаалтантай ярилцлага хийх, тодруулга, лавлагаа авах зэрэг аргуудыг ашигласан болно.

ГУРАВ. АУДИТЫН ҮР ДҮН

Асуудал 1	Цахим хуудсанд мэдээлэл байршуулах хугацааг баримтлаагүйгээс хугацаа хоцролт гарсан ба төрийн өмчит компаниудын хэрэгжилтийн дундаж 96.1 хувь, төсөл 93.3 хувиар үнэлэгдсэн. Төсөл хөтөлбөрийн мэдээллийн хугацаа баримталсан байдал өмнөх оны мөн үеэс 0.8 пунктээр буурсан байна.
Асуудлын ангилал	Нөлөө ихтэй

Шилэн дансны цахим хуудсанд жилийн туршид 27 төрлийн мэдээллийг нийт 158 удаа байршуулахаар журамласан. Мэдээллүүдийн давтамжууд харилцан адилгүй бөгөөд жил бүр, сар бүр, хагас жил бүр, тухай бүр гэсэн хугацааны товлолоор байршуулна. Гэтэл салбарын байгууллагууд тогтоосон товлот хугацаанаас хоцрох, хугацаандаа оруулсны дараа засвар өөрчлөлт хийх байдлаар мэдээллийн төлөвийг өөрчилж, хугацаа хоцролтод оруулж байна.

Шилэн дансны цахим хуудсанд шинэчлэл хийгдэж, 2023 оноос шинэ системд мэдээлэл байршуулж байгаа бөгөөд систем хугацаагаа автоматаар тоолж, хугацаандаа болон хугацаа хоцролтыг тодорхойлдог болсон. Тухай бүр оруулах мэдээллийг 7 хоногийн дотор оруулахаар журамд заасныг мөрдөхгүй байгаа нь хугацаа хоцролт өсөхөд хүргэсэн.

Нийтлэг гарч буй алдаа:

- Ажил гүйлгээний огноог бүгдийг нэг ижил өдрөөр буюу сарын сүүлийн өдрөөр мэдээлж байгаа тохиолдол гарч байна.
- Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий мөнгөн орлого, зарлагын гүйлгээ гэсэн мэдээлэл дээр хоцролт их гарсан болно.
- Тайлангийн хугацаа өнгөрсөн мэдээллийг нөхөж байршуулах.
- Тайлангийн нүүр хэсэгт хугацаандаа байршуулсан төлөвтэй боловч тухайн сарыг нээхэд мэдээллүүд хоцорсон төлөвтэй орсон зөрчил дийлэнх компаниудад гарч байна.

Салбарын хэмжээнд төрийн өмчит компаниудын хугацаандаа мэдээлэл байршуулалт 96% биелэлттэй үнэлэгдсэн.

№	Байгууллагын нэр	Зөрчилтэй мэдээллийн тоо	Үнэлгээ хувиар	№	Байгууллагын нэр	Зөрчилтэй мэдээллийн тоо	Үнэлгээ хувиар
1	"ДЦС-2" ТӨХК	3	98.1%	19	"Ховд ДС" ТӨХК	-	100%
2	"ДЦС-3" ТӨХК	1	99.4%	20	ДШГ ТӨХК	8	95%
3	"ДЦС-4" ТӨХК	20	87.3%	21	"АУЭХС" ТӨХК	20	87.3%
4	"Дарханы ДЦС" ТӨХК	2	98.7%	22	"Богдын голын УЦС" ХХК	15	90.5%
5	"ЭДЦС" ТӨХК	3	98.1%	23	"Тосонцэнгэл УЦС" ХХК	-	100%
6	"Даланзадгад ДЦС" ТӨХК	9	94.3%	24	Завхан салбар	11	93%
7	"УБЦТС" ТӨХК	3	98.1%	25	"Тайшир гуулин УЦС" ХХК	2	98.7%
8	"БНЗӨБЦТС" ТӨХК	1	99.4%	26	ББЭХС ТӨХК	15	90.5%
9	"ДБЭХС" ТӨХК	3	98.1%	27	Увс ЦТС ТӨХК	19	88%
10	"ЦДУС" ТӨХК	-	100%	28	Ховд ЦТС	16	89.9%
11	"ӨБЦТС" ТӨХК	-	100%	29	Дөргөний УЦС ТӨХК	10	93.7%
12	"ЭБЦТС" ТӨХК	3	97%	30	УГДХС ТӨХК	10	93.7%
13	"УБДС" ТӨХК	9	94.3%	31	ТГДЦС ТӨХК	4	97.5%
14	"ДДС" ТӨХК	-	100%	32	ЭГУЦС ТӨХК	10	93.7%
15	"Амгалан ДС ТӨХК	1	99.4%	33	ДҮТ ТӨХК	-	100%
16	"БНДС" ТӨХК	13	91.8%	34	ЭХҮТ ТӨХК	4	97.5%
17	"НДС" ТӨХК	2	98.7%	35	Замын-Үүдийн ДС ТӨҮГ	5	96.8%
18	"Хөвсгөл ДС" ТӨХК	1	99.4%	36	ЭХЭЗХ ТӨҮГ	1	99.4%
ДҮН			96.1%				


Дэлгэрэнгүйг хавсралтаар харуулав.

Төслийн нэгжүүдийн хугацаандаа мэдээлэл байршуулалт 93,3 хувьтай байна.

№	Байгууллагын нэр	Зөрчилтэй мэдээллийн тоо	Үнэлгээ хувиар	№	Байгууллагын нэр	Зөрчилтэй мэдээллийн тоо	Үнэлгээ хувиар
1	Арван аймгийн ДС	8	95%	6	УБ хотын ТДХ төсөл	3	98.1%
2	Багануурын ЦС	3	98.1%	7	Чойр Сайншандын ЦДАШ, дэд станцын төсөл	13	91.8%

3	СЭХНТөсөл	19	88.1%	8	ЭБУЦ төсөл	11	93.1%
4	ТБЦДТСУАД төсөл	1	99.4%	9	Том чадлын хуримтлуурын төсөл	11	93.1%
5	УБХДХУАН төсөл	18	88.7%	10	ЭХТ-2	20	87.4%
ДҮН				93.3%			

Өмнөх оны мөн үетэй харьцуулахад төрийн өмчит компаниудын үзүүлэлт 5.6 пунктээр өссөн боловч төсөл хөтөлбөрүүдийн хугацаандаа тайлагналт 0.8 пунктээр буурсан байна.



Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газраас 2024.04.25-ны өдөр эрчим хүчний салбарын дотоод аудиторудад зориулсан "Сургалт-зөвлөгөө-мэдээллийн цаг"-ийг зохион байгуулсан. Хөтөлбөрийн дагуу шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт, цахим хуудасны шинэчлэлийн хүрээнд хэрхэн ажиллах, цахим хуудсанд мэдээлэл байршуулахад анхаарах асуудал, нийтлэг гарч буй алдааг танилцуулж, тэдгээрийг давтан гаргахгүй байх талаар зөвлөгөө, мэдээлэл хүргэж ажилласан нь тодорхой үр дүнд хүрсэн байна.

Шалгуур	Шилэн дансны тухай хуулийн 4.1.3.тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх; "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"
Асуудлын үндсэн шалтгаан	Хугацаа баримтлахгүй байх, мэдээллийг тухай бүрт нь байршуулахгүй, нөхөж оруулах Шинэ систем хугацааг автоматаар тоолж байгааг мэдэхгүй байх. Ажил гүйлгээг тухайн сараар үнэн зөв тайлагнахгүй дараагийн сар луу шилжүүлэх
Үр нөлөө	Хууль, журмын хэрэгжилт хангахгүй байх
Зөвлөмж	- Журамд заасан хугацааг баримталж, мэдээлэл бүрийг тогтоосон хугацааны дотор байршуулах, - Шилэн дансны систем цаг хугацааг автоматаар тооцож байгааг анхаарах, - Хугацаандаа мэдээлэл байршуулах зохион байгуулалтын арга хэмжээ авах, Тухай бүр оруулах тохиргоотой мэдээллийг 7 хоног бүр татаж мэдээлэх,

Асуудал 2	Шилэн дансны цахим хуудсанд байршуулах мэдээллийн агуулга, стандартыг баримталсан байдал 96.5 хувьтай байна.
Асуудлын ангилал	Нөлөө ихтэй
Бодит байдал	Аудитаар нийт 33 байгууллагад мэдээллийн агуулга, стандарт зөрчигдсөн, мэдээллийн талбар хоорондын уялдаа хангаагүй зөрчил илэрсэн. "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын хавсралтаар баталсан маягтын дагуу мэдээлэл байршуулахгүй, иж бүрэн хөтлөхгүй байна. Нийтлэг алдаа, зөрчлийг дурдвал: - Баримт хавсаргахгүй, багана нүдийг хоосон орхих, - Мэдээлэл дутуу байршуулах, - Тайлбар, шалтгааныг тусгахгүй байх,

	- Батлагдсан болон тодотгосон зорилтот түвшинг байршуулахгүй байх, - Мөнгөн дүнгийн нарийвчлалыг өөр хооронд нь ялгаатай оруулснаар харьцуулалт хийх боломжгүй болгох, - Мэдээлэл оруулахгүй хоосон илгээх, - Гүйцэтгэлийг өссөн дүнгээр оруулахгүй байх, - Холбоогүй мэдээлэл оруулах /нэмэлт өөрчлөлт байршуулах байтал төлөвлөгөөг оруулах/ - Ажил гүйлгээ, шийдвэрийн огноог бодитоор мэдээлэхгүй, сарын сүүлийн өдрөөр огноог оруулах зэрэг нийтлэг алдаа гаргаж байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулбал 6.6 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Мэдээллийн агуулга, стандарт <table border="1" style="margin-left: auto; margin-right: auto;"> <thead> <tr> <th>2023.12.31</th> <th>2024.12.31</th> </tr> </thead> <tbody> <tr> <td>89.4%</td> <td>96%</td> </tr> </tbody> </table> Дэлгэрэнгүйг хавсралтаар харуулав.	2023.12.31	2024.12.31	89.4%	96%
2023.12.31	2024.12.31				
89.4%	96%				
Шалгуур	Шилэн дансны тухай хуулийн 4.1.1. "мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх"; - 4.1.2. "мэдээлэл ойлгомжтой, ач холбогдолтой байх"; - "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"				
Асуудлын үндсэн шалтгаан	Холбогдох хууль, журмыг судлахгүй байх, Хавсралт маягтын дагуу хөтөлж, мэдээлэхгүй байх, Хайнга хандлага, Ажилтнууд солигдох, шинээр томилогдож буй ажилтнууд ойлголтгүй байх.				
Үр нөлөө	Хууль тогтоомжийн хэрэгжилт хангалтгүй байх				
Зөвлөмж	Мэдээллийг үнэн зөв, ойлгомжтой боловсруулж байршуулах, Маягтын дагуу иж бүрэн мэдээлэх, хоосон илгээхгүй байх, Ажил гүйлгээ, шийдвэрийн огноог тухайн гарсан өдрөөр нь мэдээлэх,				

Асуудал 3	Шилэн дансны аудитын тайлан илгээлт 97 хувьтай, 9 компани хугацаандаа илгээгээгүй байна.
Асуудлын ангилал	Нөлөө ихтэй
Бодит байдал	Шилэн дансны цахим хуудсанд байршуулсан улирлын тайланг байгууллагын админ дараа сарын 25-ны өдрийн дотор илгээх үүрэгтэй. 2024 оны 1,2 дугаар улиралд зөрчил гараагүй. 2024 оны 3-р улирлаар нийт 6 тайлан хугацаа хоцорсон. Үүнд: Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ ТӨХК, Эрчим хүчний үндэсний төв ТӨХК, Дөргөний усан цахилгаан станц ТӨХК, Увс Цахилгаан түгээх сүлжээ ХХК, Дорнод бүсийн эрчим хүчний систем ТӨХК, Замын-Үүдийн дулааны станц ТӨҮГ 2024 оны 4-р улирлын байдлаар 3 тайлан хугацаа хоцорсон. Үүнд: Эрдэнэтийн дулааны цахилгаан станц ТӨХК, Баруун бүсийн эрчим хүчний систем ТӨХК, Дарханы дулааны цахилгаан станц ТӨХК. Үнэлгээг хийхдээ хоцролтыг -10% тооцсон болно. 28 байгууллага 100% үнэлгээтэй, 9 байгууллага тайлан илгээлт 90%-иар үнэлэгдсэн. 2024 оны шилэн дансны аудитын тайлан илгээлт салбарын дундаж 97 хувьтай гарсан байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад 14 хувиар өссөн зэрэг үр дүнд хүрсэн.

	Тайлан илгээлт <table><thead><tr><th>Series1</th><th>2023.12.31</th><th>2024.12.31</th></tr></thead><tbody><tr><td></td><td>83%</td><td>97%</td></tr></tbody></table>	Series1	2023.12.31	2024.12.31		83%	97%
Series1	2023.12.31	2024.12.31					
	83%	97%					
	Дэлгэрэнгүйг хавсралтаар харуулав.						
Шалгуур	Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын 8.2-т "Дотоодын аудитын алба нь улирлын нэгдсэн тайланг санхүү төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад дараа сарын 25-ны дотор хүргүүлнэ"						
Асуудлын үндсэн шалтгаан	Ажилтнуудын ажлын хариуцлага сул байна. ХШУДАГ-аас улирал бүр тайланг хугацаандаа илгээх талаар "Шилэн данс-ЭХЯ" /105 гишүүнтэй/ vibeg групп дээр мэдээлдэг боловч алдаа давтагдсаар байна.						
Үр нөлөө	Тайлан хугацаандаа илгээгдээгүй. ЗГХХГ-аас ЭХЯ-ны 2024 оны үйл ажиллагааны хэрэгжилтэд хийх ХШҮ-ний байгууллагын ил тод байдлын үнэлгээнд нөлөөлнө.						
Зөвлөмж	Байгууллагын админууд аудитын тайланг журамд заасан хугацаанд илгээх						

4. ДҮГНЭЛТ

- Шилэн дансны хуулийн хэрэгжилт 2024 оны жилийн эцсийн байдлаар нийт дүнгээр 95.8 хувьтай байгааг өмнөх оны мөн үеийн 92.3 хувьтай харьцуулахад 3.5 хувиар өссөн эерэг үзүүлэлттэй байна. Үүнд:
 - Төрийн өмчит компаниудын цахим хуудас хөтлөлт сайжирч 96.0% хүрч өмнөх оноос 7.6%-иар өссөн.
 - Төсөл хөтөлбөрийн шилэн дансны цахим хуудасны хөтлөлт 95.5% байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 0.7 хувиар буурсан нь салбарын дүнд сөргөөр нөлөөлж байна.

Дотоод аудитаар биет тестүүд, нотлох баримтууд, аудитын дүнд үндэслэн эрчим хүчний салбарт хэрэгжиж буй төсөл, хөтөлбөрүүдийн шилэн дансны хуулийн хэрэгжилтэд **"САЙЖРУУЛАЛТ ХЭРЭГТЭЙ"** үнэлгээг гаргаж байна.

ТАНИЛЦСАН:

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ,
ДОТООД АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА

Х.БЕКБОЛАТ

БОЛОВСРУУЛСАН:

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ,
ДОТООД АУДИТЫН ГАЗРЫН ШИНЖЭЭЧ

Н.АМАРТӨВШИН

АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

Т.МӨНХЗУЛ

2025.02.21

НЭГТГЭЛ

д/д	Байгууллагын нэр	Үнэлгээ 2023.12.31	Цахим хуудас хөтлөлт үзүүлэлт бүрээр 2024.12.31			ҮНЭЛГЭЭ 2024.12.31	
			Хугацаа	Агуулга, стандартын дагуу тайлагнасан байдал /хувь/	Тайлан илгээлт	Хувь	Түвшин
1	"ЦДҮС" ТӨХК	90.0%	100.0%	100.0%	100.0%	100.0%	I
2	"ДДС" ТӨХК	83.0%	100.0%	100.0%	100.0%	100.0%	
3	"ДҮГ" ХХК	99.8%	100.0%	100.0%	100.0%	100.0%	
4	"Ховд ДС" ТӨХК	95.2%	100.0%	100.0%	100.0%	99.8%	
5	"Хөвсгөл ДС" ТӨХК	93.7%	99.4%	100.0%	100.0%	99.8%	
6	Амгалан ДС ХХК	93.3%	99.4%	100.0%	100.0%	99.8%	
7	"БНЗӨБЦТС" ТӨХК	93.0%	99.4%	100.0%	100.0%	99.1%	
8	ЭХЯ	99.3%	97.3%	100.0%	100.0%	99.0%	
9	"ЭБЦТС" ТӨХК	93.7%	97.0%	100.0%	100.0%	98.7%	II
10	ТЕЗ	100.0%	96.2%	100.0%	100.0%	98.1%	
11	"ДЦС-3" ТӨХК	87.8%	99.4%	94.9%	100.0%	98.1%	
12	"ӨБЦТС" ТӨХК	92.7%	100.0%	94.3%	100.0%	97.5%	
13	Тосонцэнгэл УЦС ХХК	93.9%	100.0%	92.4%	100.0%	97.3%	
14	ЭХЭЭХ ТӨҮГ	86.9%	99.4%	92.4%	100.0%	97.3%	
15	"БНДС" ТӨХК	89.7%	91.8%	100.0%	100.0%	97.0%	
16	Тайшир Гуулин УЦС ХХК	92.3%	98.7%	92.4%	100.0%	96.6%	
17	Ховд ЦТС ХХК	89.4%	89.9%	100.0%	100.0%	96.6%	
18	ТТДЦС ТӨХХК	87.6%	97.5%	92.4%	100.0%	96.8%	
19	"УБДС" ТӨХК	87.0%	94.3%	96.2%	100.0%	96.8%	
20	ДЦС-2 ТӨХК	82.6%	98.1%	92.4%	100.0%	96.8%	
21	"ДБЭХС" ТӨХК	84.3%	98.1%	99.4%	90.0%	95.8%	
22	Налайхын ДС ТӨХК	92.0%	98.7%	88.6%	100.0%	95.8%	
23	Улаангомын дулааны II станц ТӨХК	86.3%	93.7%	92.4%	100.0%	95.4%	
24	"ЭДЦС" ТӨХК	85.5%	98.1%	98.1%	90.0%	95.4%	
25	Эгийн голын УЦС ТӨХХК	89.4%	93.7%	91.8%	100.0%	95.2%	
26	"ДШГ" ТӨХК	87.6%	95.0%	98.7%	90.0%	94.6%	
27	"Дарханы ДЦС" ТӨХК	93.8%	98.7%	94.9%	90.0%	94.5%	
28	Завхан салбар	83.8%	93.0%	90.5%	100.0%	94.5%	
29	Богдын голын УЦС ХХК	89.6%	90.5%	91.8%	100.0%	94.1%	
30	ЭХҮТ ТӨХХК	90.4%	97.5%	92.4%	90.0%	93.3%	
31	"УБЦТС" ТӨХК	82.0%	98.1%	91.1%	90.0%	93.1%	
32	Даланзадгадын ДЦС ТӨХК	81.9%	94.3%	84.8%	100.0%	93.0%	
33	"ДЦС-4" ТӨХК	83.7%	87.3%	89.2%	100.0%	92.2%	
34	Дөргөний УЦС ТӨХК	78.4%	93.7%	93.0%	90.0%	92.2%	
35	Замын-Үүдийн ДС ТӨҮГ	79.0%	96.8%	89.2%	90.0%	92.0%	
36	"АУЭХС" ТӨХК	80.2%	87.3%	82.9%	100.0%	90.1%	
37	"АУЭХС" ТӨХК	82.7%	88.0%	91.8%	90.0%	89.9%	III
38	Увс ЦТС ТӨХК	79.0%	90.5%	84.2%	90.0%	88.2%	
	"ББЭХС" ТӨХК	88.4%	96.1%	94.5%	97.4%	96.0%	I
	ТЕЗ, ТӨХК-ИЙН ДҮН	98.5%	99.4%	100.0%		99.7%	
1	ТБЦДТ сүлжээний ҮАД төсөл	99.1%	98.1%	100.0%		99.1%	II
2	Багануурын ЦСТөсөл	97.1%	98.1%	96.2%		97.2%	
3	УБ хотын төвлөрсөн дулаан хангамжийн төсөл	96.0%	93.1%	99.4%		96.3%	
4	Том чадлын хуримтлуур төсөл	99.4%	95.0%	97.0%		96.0%	
5	10 аймгийн төвд ДС барих төсөл	96.1%	91.8%	100.0%		95.9%	
6	Чойр Сайншандын ЦДАШ төсөл	95.0%	87.4%	100.0%		93.7%	
7	Эрчим хүчний төсөл-2	94.6%	93.1%	92.5%		92.8%	
8	"ЭБУЦС" төсөл	90.1%	88.7%	96.8%		92.8%	
9	УБ хотын дулаан хангамжийн ҮАН төсөл	96.3%	88.1%	93.6%		90.9%	
10	СЭХ-ийг нэмэгдүүлэх төсөл	96.2%	93.3%	97.6%		95.5%	
	ТӨСЛИЙН ДҮН	92.3%				95.8%	
	НИЙТ ДҮН						